

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/11/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261885 Цахим хаяг: bolorderened@audit.gov.mn
Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал: Н.Цэрэнханд
Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.БАЛЖИННЯМ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024. 03. 15 № 07/714

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн нийлүүлэх эрчим хүчний чадал, энергийн саналыг Эрчим хүчний зохицуулах хороо хүлээн авч, хянан нэг худалдан авагчийн загварын тайланд мөрдөх тариф, мөнгөн урсгалын коэффициентийг баталдаг. Тайлант оны нэг худалдан авагч, экспорт импортын тайлангийн тарифын эерэг зөрүү 8,842.0 сая төгрөгөөр өмнөх онуудын тарифын сөрөг зөрүү 6,880.0 сая төгрөгийг нөхөж, 1,962.0 сая төгрөгийн тарифын эерэг зөрүүг хойшлогдсон өр төлбөрөөр тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь 2018 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд 2021 онд эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд хэрэглэж байгаа нэг худалдан авагчийн загварыг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Гэтэл тайлант онд 170.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг нээлттэй тендер зарлаж, 155.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 98.0 хувийн хэрэгжилттэй байна гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СБ

А9443 900618
7023030000

Ц.НАРАНЧИМЭГ

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,862,348,787.10	5,829,767,708.31
1.1.2	Дансны авлага	58,338,523,367.17	52,201,490,367.94
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,328,637,569.28	3,805,211,798.87
1.1.4	Бусад авлага	105,034,547.31	10,135,834,893.59
1.1.5	Бараа материал	253,857,867.13	350,773,457.90
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	29,123,424.64	2,365,465.88
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	70,917,525,562.63	72,325,443,692.49
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,326,461,419.04	10,746,721,490.31
1.2.2	Биет бус хөрөнгө	1,903,752,730.22	1,363,449,121.79
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	6,879,984,404.17	-
1.2.4	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,110,198,553.43	12,110,170,612.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	89,027,724,116.07	84,435,614,304.59
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	74,477,106,341.46	67,100,493,702.66
2.1.1.2	Татварын өр	1,149,248,350.25	894,748,650.55
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	556,314,279.11	676,400,096.66
2.1.1.4	Бусад богино хугацаат өр төлбөр	351,331,342.38	139,528,416.37
2.1.1.5	Богино хугацаат өр төлбөрийн дүн	76,534,004,313.20	68,811,170,866.24
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,351,018,099.86	5,913,016,763.68
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	790,022,460.38	4,251,011,462.07
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	111,112,148.15	150,816,074.27
2.1.2.4	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,252,152,708.39	10,314,844,300.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	83,786,157,021.59	79,126,015,166.26
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,811,705,231.02	1,811,705,231.02
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	587,815,153.11	587,815,153.11
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	140,628,482.55	140,628,482.55
2.3.4	Хуримтлагдсан ашиг	2,701,418,227.80	2,769,450,271.65
2.3.4.1	Тайлангийн үеийн ашиг	-	107,800,243.41
2.3.4.2	Өмнөх үеийн ашиг	2,701,418,227.80	2,661,650,028.24
2.3.5	Эздийн өмчийн дүн	5,241,567,094.48	5,309,599,138.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	89,027,724,116.07	84,435,614,304.59

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,103,528,679,427.60	1,442,518,781,436.96
Борлуулалтын өртөг	1,109,158,008,060.69	1,447,600,063,440.57
Нийт ашиг(алдагдал)	(5,629,328,633.09)	(5,081,282,003.61)
Хүүний орлого		165,936,491.30
Бусад орлого	9,961,188,126.94	9,053,309,055.94
Борлуулалт, маркетингийн зардал	577,361,035.91	717,139,313.73
Ерөнхий ба удирдлагын зардал	1,882,442,165.38	2,299,754,236.71
Санхүүгийн зардал	133,708,862.74	126,033,418.02
Бусад зардал	869,948,679.28	751,342,136.11
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(675,612,500.04)	(78,391,937.35)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(29,756,461.47)	136,363.64
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	163,029,789.03	165,438,865.35
Орлогын татварын зардал	-	17,934,695.82
Хойшлогдсон татварын зардал	51,705,046.69	39,703,926.12
Татварын дараах ашиг (алдагдал)	111,324,742.34	107,800,243.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	111,324,742.34	107,800,243.41
Орлогын нийт дүн	1,113,489,867,554.54	1,451,738,026,984.20

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	3,420,935,914.22	5,961,084,780.90
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(830,842,428.76)	(830,842,428.76)
Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,590,093,485.46	5,130,242,352.14
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	111,324,742.34	111,324,742.34
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,701,418,227.80	5,241,567,094.48
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	15,894,171.61	15,894,171.61
Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,661,650,028.24	5,201,798,894.92
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	107,800,243.41	107,800,243.41
Зарласан ногдол ашиг				(55,662,371.17)	(55,662,371.17)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,769,450,271.65	5,309,599,138.33

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,403,474,788,352.37	1,485,280,723,760.47
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,181,097,490,014.88	1,484,491,529,941.04
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	331,200.00	12,150,900.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	222,376,967,137.49	777,042,919.43
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,392,898,188,671.63	1,487,103,902,496.93
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,524,655,124.17	5,582,949,454.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,230,528,035.57	1,478,076,753.23
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,139,858,101,501.58	1,438,427,380,319.91
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	529,192,858.52	639,835,979.02
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	144,792,476.00	100,084,663.38
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	133,708,862.74	126,033,418.02
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	24,934,739,303.44	30,166,352,638.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	12,506,780.00	11,257,297.13
1.2.9	Бусад мөнгөн зарлага	221,529,963,729.61	10,571,931,972.95
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,576,599,680.74	(1,823,178,736.46)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	166,086,491.30
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	150,000.00
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	-	165,936,491.30
2.2	Мөнгөн зарлагын дүн	1,967,622,140.61	1,701,246,069.07
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,831,708,936.86	1,401,208,940.07
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	135,913,203.75	300,037,129.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,967,622,140.61)	(1,535,159,577.77)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	180,447,308.21	3,424,346,534.97
3.1.1	Бусад	180,447,308.21	3,424,346,534.97
3.2	Мөнгөн зарлагын дүн	3,412,013,962.82	4,098,589,299.53
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	438,001,336.18	438,001,336.18
3.2.2	Төлсөн ногдол ашиг	673,969,143.00	55,662,371.17
3.2.3	Бусад	2,300,043,483.64	3,604,925,592.18
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,231,566,654.61)	(674,242,764.56)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,377,410,885.52	(4,032,581,078.79)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,484,937,901.58	9,862,348,787.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,862,348,787.10	5,829,767,708.31

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/сая төгрөгөөр/

№	Техник эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Цахилгаан эрчим хүч:	Нийт хэрэглээ /боловсруулалтаар/	сая.кВтц	8,526.9	8,824.6	297.7	103.5
		Боловсруулалт	сая.кВтц	7,740.2	8,077.8	337.6	104.4
		Түгээлтээр	сая.кВтц	6,854.9	7,156.0	301.1	104.4
	Дулааны эрчим хүч:	Боловсруулалт	мян.Гкал	10,550.5	10,355.9	(194.6)	98.2
		Түгээлтээр	мян.Гкал	10,268.5	10,073.6	(194.9)	98.1
2	Нийт орлого		сая.төг	11,318.6	11,457.9	139.3	101.2
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	10,623.3	10,623.3	-	100.0
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	695.3	834.6	139.3	120.0
3	Нийт зардал		сая.төг	11,313.9	11,302.9	(11.0)	99.9
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	10,706.8	10,489.4	(217.4)	97.9
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	607.1	813.5	206.4	134.0
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	4.7	155.0	150.3	3437.2
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	4.2	107.8	103.6	3053.7
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.0	0.99	(0.01)	99.0
7	Нийт авлага		сая.төг	150.0	345.6	195.6	230.4
	Үүнээс:	Эрчим хүчний бусад	сая.төг	-	-	-	-
			сая.төг	150.0	345.6	195.6	230.4
8	Нийт өглөг		сая.төг	7,133.9	8,578.7	1,444.8	120.3
	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	6,733.9	8,352.8	1,618.9	124.0
		Богино хугацаат өр төлбөр	сая.төг	400.0	225.9	(174.1)	(43.5)
9	Нийт ажилчдын тоо		тоо	120.0	116.0	(4.0)	(-3.3)
10	Нийт цалингийн сан		сая.төг	5,846.8	5,846.8	-	100.0
11	Диспетчерийн үр ашигтай зохицуулалт, горим төлөвлөлт		төг	132.96	145.24	12.3	109.2
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	1,823.8	1,752.8	(71.0)	96.1
	Үүнээс:	Их засвар	сая.төг	92.6	91.6	(1.0)	98.9
		ТЗБАХ	сая.төг	584.8	557.3	(27.5)	62.9
		Хөрөнгө оруулалт	сая.төг	1,146.4	1,103.9	(42.5)	96.3

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 739.4 сая төгрөгийн 3 зөрчилд¹ зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2023-2024 оны "хамтын гэрээ"-ний дагуу ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардалд орон сууцны дэмжлэгт 90.0 сая төгрөг, шагнал урамшуулалд 121.0 сая төгрөг, 1 удаагийн буцалтгүй тусламжид 94.2 сая төгрөг нийт 305.2 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардалд орон сууцны дэмжлэгт 380.0 сая төгрөг бүгд 685.2 сая төгрөгөөр орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар бүртгэж татвар төлөхийн өмнөх ашгийг бууруулсан байна.	1	685,277.3					1	685,277.3				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Нэг удаагийн буцалтгүй тусламж болон орон сууцны дэмжлэгээс 54.1 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаж тайлагнасан байна	1	54,090.0					1	54,090.0			
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үлдэх өртөггүй 1521 нэр төрлийн 6,763.2 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-					1	-			
Дүн	3	739,367.3					3	739,367.3			

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 11.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>						
Тус байгууллага нь тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах саналдаа төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашгийг тусгаагүй байна.	1				1	
Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээний дагуу Хөдөлмөрийн баатар, гавьяат, одон медаль, эрчим хүчний болон бусад салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан хүмүүст сар бүр цалин дээр нь нэмэгдэл олгосон байна.	1	11,792.0	1	11,792.0		
Дүн	2	11,792.0	1	11,792.0	1	-